

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА


/Б.СЭРГЭЛЭН/

“БТЕГ” ХХК-ИЙН БАЯНГОЛ УУРХАЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


/Ж.МӨНХБААТАР/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

№ 01

20²⁴ оны 10 дугаар сарын 31 өдөр

Ерөө сум

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга Б.Сэргэлэн (цаашид “Засаг дарга гэх), нөгөө талаас “БТЕГ” ХХК-ийн Баянгол уурхайн Гүйцэтгэх захирал Ж.Мөнхбаатар /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/ нар хамтран 2024 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж акт үйлдэв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Хамтран ажиллах гэрээний нийтлэг заалтуудыг 2 тал хамтран 20²⁴ оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 20²⁴ оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд орон нутгийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, санал хүсэлтийг дэмжин хэрэгжүүлж гүйцэтгэв.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Ерөө сумын засаг дарга нь санхүүжилтийг заагдсан төсөл хөтөлбөрт бүрэн зарцуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал ашиглах, олборлох үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр ханган, гэрээний 2 дугаар заалтад заасан эрх үүргээ биелүүлсэн байна.

- Засаг дарга нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажилласан.

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан төсөл, орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжих боломжтой төсөл, саналыг сонгон санхүүжүүлж шийдвэрлүүлж ажиллаа.

ГУРАВ. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

3.1 “БТЕГ” ХХК нь дээрх гэрээний 3 дахь заалтуудыг мөрдлөг болгон гэрээний эрх үүргээ бүрэн биелүүлж ажилласан байна.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг мэргэжил олгох сургалтад хамруулах талаар сумын хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

- "БТЕГ" ХХК болон түүний салбар компанид ажиллаж буй орон нутгийн харьяалалтай ажилтнуудыг дараах чиглэлд сургалтад хамруулсан. Үүнд: Оосорлогч дохиочин, аюулгүй ажиллагаа хариуцагчийн сургалтад 31, Даралтат сав, шугам хоолойтой харьцах эрх олгох сургалтад 9, Нам даралтат зуухны машинчийн үнэмлэх олгох сургалтад 21, нийт 61 ажилтныг 7,630,000 төгрөгийн мөнгөн дүнтэй ажлын байрны мэргэжлийн мэдлэг олгох, ур чадвар дээшлүүлэх сургалтад байгууллагын зардлаар үнэ төлбөргүй хамруулж, ажлын байранд тэнцэх нөхцлийг бүрдүүлсэн.
- Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн засаг захиргаа болон хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллаж ажлын байрны сул орон тоог ил тод нээлттэй хэлбэрээр мэдээлж ажилласан.
- 2024 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Ерөө сум, Бугант тосгонд ажлын байрны нээлттэй өдөрлөгийг 3 удаагийн давтамжтай зохион байгуулсан ба нийт 319 анкет хүлээн авсан ба 282 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

3.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн талаар сумын иргэдэд жилд хоёроос доошгүй удаа мэдээлэл өгч ажиллах;

- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Ерөө сум, Бугант тосгонд ажлын байрны нээлттэй өдөрлөгийг 3 удаагийн давтамжтай зохион байгуулсан ба

3.1.4 Бараа худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбар компани нь орон нутгийн газар тариалангийн аж ахуй эрхэлдэг орон нутгийн 8 иргэн, 4 хоршооноос 44тн 971.8кг хүнсний ногоо, 8325 литр сүү, нийт 82,339,800.00 төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

3.1.5 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалахад ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг бүрэн хангаж ажилласан
- Ерөө сумын 3-р багийн нутаг Бугант тосгоны "ИХ ӨЛӨНТ" нэртэй газарт эзэнгүй орхигдсон 13га талбайд өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн төрийн захиргааны байгууллагад актаар хүлээлгэн өгсөн

- Орон нутгийн ойн мэргэжлийн байгууллагуудын төсөл хөтөлбөрийг дэмжиж Ерөө сумын мэргэжлийн байгууллагууд болох “Номин од”ХХК, “Бугант минж”ХХК, “Бугант трейд”ХХК, “Бугант чулуут овоо”ХХК зэрэг байгууллагуудтай хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн ойн санг 200га талбайгаар нэмэгдүүлэн ажилласан
- Усны нөөц хомсдохоос сэргийлж уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас үүсэх шүүрлийн ус болон газар доорх усны нөлөөллийг тодорхойлох зорилгоор усны мониторингийн цооног нэмэлтээр өрөмдөж, гидрогеологийн судалгааг өөрийн хөрөнгөөр усны мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.
- Амьтан хамгааллын чиглэлээр шаардлагатай газруудад үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, ашигт долооцыг ойн цоорхойд байршуулж ажилласан.
- Гадрагын усны бохирдолоос урьдчилан сэргийлэх усан орчныг хамгаалах зорилгоор жил бүр нөлөөллийн бүсийн орчинд байрлах голын цэвэрлэгээний дотоод төлөвлөгөөг боловсруулан батлуулж хуваарийн дагуу тайлант онд голын дагуу 3 удаагийн нэгдсэн цэвэрлээг зохион байгуулж ажилласан
- Уурхайн ашиглалтын талбайд өртөгдсөн моддыг иргэдэд түлээний хэрэгцээнд нийлүүлж ажилласан.
- Орон нутгийн 100 жилийн ойг тохиолдуулан Ерөө сумын засмал зам дагуу, улиас-99ш, агч-82ш, монос-229ш, үхрийн нүд 54ш, голт бор модны тарьц 66ш тарьж арчлах хамгаалах ажлыг гүйцэтгэсэн.

3.1.6 Онцгой нөхцөл байдлын /гамшигийн/ үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

- Гамшигийн үед /үерийн ус төв замд боогдон айлууд усанд автах нөхцөл байдал үүссэн үед сайн дурын үндсэн дээр техник гаргаж ус зайлуулах шуудуу татах, бугант тосгоны төв орон нутгийн замын эвдрэлийг засах ажилд ажиллах хүчний туслалцаа үзүүлж ажиллалаа.

3.1.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боломжит бүсэд нутгийн малчин иргэд зусах, өвс хадлан бэлтгэх боломжийг бүрдүүлэх;

- Уурхайн эзэмшлийн талбайн боломжит бүсэд нутгийн малчин иргэдийг зунших, өвс хадлан бэлтгэх боломжийг байнга бүрдүүлж өгдөг.

3.1.8 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран хоёр талын саналыг зөвшилцөн тэмдэглэн өнгөрүүлэх;

- Мод тарих үндэсний өдрүүдэд төрийн захиргааны байгууллагын хүсэлтийн дагуу хамтран ажиллаж хайлаасны тарьц 200ш, монос, үхрийн нүд, өрөл, голт борын тарьц тус бүр 50, 50 ширхэгийг сумын ногоон байгууламжинд тариулахаар дотоод мод үржүүлгийн талбайгаас нийлүүлсэн.

3.1.10 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийт ажиллагсадын тодорхой хувийг сумын иргэдээс бүрдүүлэх;

- 2024 онд компанийн хэмжээнд нийт 206 иргэнийг ажлын байраар хангасан ба түүний 60,6 хувь буюу 125 нь Сэлэнгэ аймгаас авч ажиллалаа. Сэлэнгэ аймгаас бүрдүүлсэн 125 шинэ ажилтны 41.6 хувь буюу 52 иргэн Ерөө сум болон Бугант тосгоны иргэдийг ажлын байраар хангаж ажилласан.

3.1.11 Орон нутгийн иргэдийг уурхайн дотоод дүрэм, журам болон түүнд нийцүүлэн гаргасан дагалдах журамд заасан хуваарьт цагаар саадгүй дамжин өнгөрөх боломжоор хангах;

- Орон нутгийн иргэдийг уурхайн дотоод дүрэм журамд заасан хувиарт цагаар дотоод замаар саадгүй дамжин өнгөрүүлж байна.

3.1.12 Ерөө суманд спорт заал барих ажлыг хийж гүйцэтгэх;

- Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан мөн тухайн ажлыг хийж гүйцэтгэх машин техник дутмаг байсан учраас хойшлуулан 2025 онд хийж гүйцэтгэхээр ажлын төлөвлөгөөнд тусгалаа.

Орон нутгийн дэд бүтэц, хөгжлийг дэмжих чиглэлээр хийгдсэн ажил

№	Сум, тосгодын нэр	Мөнгөн дүн	Зориулалт	Санхүүжилт хийсэн	
				Огноо	Мөнгөн дүн
1	Ерөө сум Бугант тосгон	2,500,000.00	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	2024.02.06	2,500,000.00
2	Ерөө сум ЗДТГ	1,500,000.00	Ерөө сумын Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	2024.02.06	1,500,000.00
3	Ерөө сум Бугант тосгон	5,379,400.00	Бугант хоккейн холбоо тэмцээний зардал	2024.02.15	5,379,400.00
4	Ерөө сум ЕБСургууль	2,500,000.00	Сурагчдын сагсан бөмбөгийн тэмцээний зардал	2024.03.15	2,500,000.00
5	Ерөө сум ЗДТГ	3,000,000.00	Оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэг	2024.05.22	3,000,000.00
6	Ерөө сум, Бугант тосгон	23,277,000.00	Орон нутгийн хүүхэд залуучуудыг хөгжүүлэх	2024.05.31	672,000.00
					1,785,000.00
					20,820,000.00
7	Ерөө сум ЗДТГ	75,000,000.00	Ерөө сумын 100 жилийн ойд хандив /Бидний бахархалт Ерөө нутаг НҮТББ-д/	2024.08.07	75,000,000.00
8	Сэлэнгэ аймаг Ерөө сум ЗДТГ	45,000,000.00	Ерөө сум Бугант тосгоны оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг	2024.10.14	45,000,000.00
9	Сэлэнгэ аймаг Ерөө сум	30,069,666.00	Ерөө сумын зочид угтах хаалганы орчинд шат, хамгаалалтын хашаа шинээр байгуулах	2024.06.28	30,069,666.00
НИЙТ					188,226,066.00

**ТАВ. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ, ГЭРЭЭ ХҮЧИН
ТӨГӨЛДӨР БАЙХ ЗААЛТЫН БИЕЛЭЛТ**

2024 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх” тухай гэрээний дагуу **188,226,066.00** төгрөгийн мөнгөн тусламж болон бусад төрлийн техник, хүн хүчний туслалцааг үзүүлэн ажлыг хангалттай хэмжээнд төлөвлөөг биелэгдсэн гэж дүгнэсэн тул цаашид гэрээг үргэлжлүүлэх боломжтой гэж үзлээ.

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН ТАЛУУД

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

..... /С.ЦЭВЭЛМАА/



“БОЛДТӨМӨР ЕРӨӨ ГОЛ”ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

..... /Г.АРИУНТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б. Сэргэлэн Б. СЭРГЭЛЭН

2024 оны 02 сарын 19



“ИНФИНТИ СПЭЙС” ХХК-ИЙН

ХАНДГАЙТ УУРХАЙН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ *Б. Золзаяа* Б. ЗОЛЗАЯА

2024 оны 02 сарын 19



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

№ 02

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга Б.Сэргэлэн (цаашид “Засаг дарга гэх), нөгөө талаас “Инфинити Спэйс” ХХК-ийн Хандгайт уурхайн Гүйцэтгэх захирал Б. Золзаяа /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/ нар хамтран 2024 оны 02 сарын 19 өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж акт үйлдэв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Хамтран ажиллах гэрээний нийтлэг заалтуудыг 2 тал хамтран 2024 оны 02 дугаар сарын 02-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ний өдрийг хүртэл хугацаанд орон нутгийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, санал хүсэлтийг дэмжин хэрэгжүүлж гүйцэтгэв.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Ерөө сумын засаг дарга нь санхүүжилтийг заагдсан төсөл хөтөлбөрт бүрэн зарцуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал ашиглах, олборлох үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр ханган, гэрээний 2 дугаар заалтад заасан эрх үүргээ биелүүлсэн байна.

- Засаг дарга нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажилласан.

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан төсөл, орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжих боломжтой төсөл, саналыг сонгон санхүүжүүлж шийдвэрлүүлж ажиллаа.

ГУРАВ. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

3.1 “ИНФИНТИ СПЭЙС” ХХК нь гэрээний 3 дахь заалтуудыг мөрдлөг болгон гэрээний эрх үүргээ бүрэн биелүүлж ажилласан байна.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны чиглэлээр

- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг бүрэн хангаж ажилласан.
- Ерөө сумын 3-р багийн нутаг Бугант тосгоны “ИХ ӨЛӨНТ” нэртэй газарт эзэнгүй орхигдсон 7га талбайд өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийг 154 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн төрийн захиргааны байгууллагад актаар хүлээлгэн өгсөн.
- Орон нутгийн ойн мэргэжлийн байгууллагуудын төсөл хөтөлбөрийг дэмжиж Ерөө сумын Модон гүүр ХХК-иас тарьц суулгац нийлүүлэх гэрээ байгуулан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн ойн санг 13 га талбайгаар нэмэгдүүлэх ажлыг хамтарч хийсэн.
- Усны нөөц хомсдохоос сэргийлж булгийн ундарга, урсац, ус цуглуулах талбайг нэмэгдүүлэх, цэнгэг байдлыг хамгаалах зорилгоор Булгийн голын эхийг хашаажуулан бургас тарьж хамгаалсан.
- Ерөө сумын 100 жилийн ойг тохиолдуулан соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчилах зорилгоор ЕБС-н сурагчидын дунд “Бидний бахархалт – Ерөө нутаг” гар зургийн уралдааныг зохион байгуулж шалгарсан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргасан.
- Амьтан хамгааллын чиглэлээр ан амьтдад биотехникийн арга хэмжээгээр амьд үлдэх, үр төлөө үлдээх нөхцөлийг сайжруулах зорилгоор эхний ээлжинд зэрлэг уулын туруутан амьтдад зориулан уст цэгт амьтад явдаг жим дагуу ашигт долооц болон өвсийг тарааж байршуулсан.
- Гадрагын усны бохирдолоос урьдчилан сэргийлэх усан орчныг хамгаалах зорилгоор жил бүр нөлөөлийн бүсэд байрлах Булгийн голын цэвэрлэгээний дотоод төлөвлөгөөг боловсруулан батлуулж хуваарийн дагуу голын их цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан.
- Уурхайн ашиглалтын талбайд өртөгдсөн моддыг орон нутгийн иргэд болон малчдад түлээний хэрэгцээнд нийлүүлж ажилласан.
- Орон нутгийн иргэдийг уурхайн дотоод дүрэм журамд заасан хувиарт цагаар дотоод замаар саадгүй дамжин өнгөрүүлж байна.
- Ерөө сумын олон нийтийн социал группд Хандгайт уурхайн байгаль орчны үйл ажиллагааны танилцуулгыг 3 минутын шторк видео бичлэгээр танилцуулсан.
- Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх үйлчилгээний “ТӨГӨЛДӨР ЕРӨӨ” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан хамтран ажилласан.
- 1000 ширхэг тарьц Ерөнхий боловсролын сургуульд бэлэглэсэн.

Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн ажил

Байгууллагын хүний нөөцийн бодлого нь тавигдах шаардлагад тэнцсэн сум, орон нутгийн ажил горилогчдыг нэн тэргүүнд сонгон шалгаруулж сул орон тоог нөхөхөд чиглэж байгаа бөгөөд холбогдох төрийн алба хаагчидтай хамтран нээлттэй, ил тод зарлаж хамтран ажиллаж байна. 2024 онд Сүхбаатар сум, Ерөө сум, Бугант тосгонд нийт 3 удаа “Ажлын байрны нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулан 118 анкет хүлээн авч, давхардсан

тоогоор 259 иргэнд байгууллага, ажлын байрны талаар мэдээ, мэдээлэл, анкет бөглөх, сонгон шалгаруулалтын үе шатны мэдлэг олгох зөвлөгөө өгч ажилласан.

2024 онд нийт 59 ажилтан шинээр авсан бөгөөд үүнээс орон нутгийн харьяалалтай 21 иргэнийг ажлын байраар хангасан нь 35.6 хувийг эзлэж байна. Тухайн 21 ажилтны 42.5 хувь буюу 9 ажилтан Ерөө сумын оршин суугчид байна.

2,060,000 төгрөгийн мөнгөн дүнтэй “Оосорлогч дохиочин, Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтны сургалт”-д орон нутгийн харьяалалтай 12 ажилтныг үнэ төлбөргүй хамруулж, мэргэжлийн үнэмлэх олгон холбогдох дүрэм, журмын дагуу ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлж ажилласан.

Орон нутгийн дэд бүтэц, хөгжлийг дэмжих чиглэлээр хийгдсэн ажил

№	Сум, тосгодын нэр	Мөнгөн дүн мян.төг	Зориулалт	Санхүүжилт хийсэн	
				Огноо	Мөнгөн дүн мян.төг
1	Ерөө сумын ЕБС	1,800.000	Гар зургийн уралдааны шагнал	2024.07.16	1,800.000
2	Ерөө сумын ЕБС	1,000.000	Спорт өрөлтийн сургагч багш бэлтгэх сургалтын хандив	2024.10.10	1,000.000
3	Ерөө сум ЗДТГ	75,000,000.00	Ерөө сумын 100 жилийн ойд хандив /Бидний бахархалт Ерөө нутаг НҮТББ-д/	2024.07.08	75,000,000.00
4	Ерөө сум ЗДТГ	50,000.000	100 жилийн ойн хандив /Бидний бахархалт Ерөө нутаг НҮТББ-д/	2023.12.22	50,000.000
	Нийт				127,800,000

ТАВ. ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ, ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙХ ЗААЛТЫН БИЕЛЭЛТ

2024 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх” тухай гэрээний дагуу **127,800,000** төгрөгийн мөнгөн тусламж болон бусад төрлийн техник, хүн хүчний тусалцааг үзүүлэн ажлыг хангалттай хэмжээнд төлөвлөөг биелэгдсэн гэж дүгнэсэн тул цаашид гэрээг үргэлжлүүлэх боломжтой гэж үзлээ.

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН ТАЛУУД

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

..... /С.ЦЭВЭЛМАА/



“ИНФИНТИ СПЭЙС” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР

Байгальмаа/Д.БАЙГАЛЬЗАЯА/



№ 03

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН АКТ

Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрлийн талбайд уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн(цаашид Засаг дарга гэх) нөгөө талаас “Хүннүстийл” ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) нар хамтран 2024 оны 07-р сарын 03-ны өдөр байгуулсан №03 тоот Нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэж акт үйлдэв.

Нэг. Засаг даргын эрх үүрэг

- Нутгийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олборлох үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр ханган хариуцлагын гэрээний 2 дугаар заатанд тусгасан эрх үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.
- Орон нутгийн иргэдийн санал болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлж иргэдэд тухай бүрт нь мэдээлэл өгч ажиллаа.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн зохих хугацаанд шийдвэрлэж хариуг өгч ирсэн.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

“Хүннүстийл” ХХК нь нийгмийн хариуцлагын гэрээний 3 дахь заалтуудыг хамтран хэрэгжүүлж ажиллаж ирлээ.

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулахад нутгийн захирганы байгууллага болон орон нутгийн иргэдээс саад учруулсан асуудал гараагүй байна.

2.Шаардлагатай ажлын байр түүнд тавигдах шаардлагыг ил тод нээлттэй хэлбэрээр ЗАНГИА.МН болон бусад сайтуудаар ажлын байрны зарыг 4 удаа тавьж байршуулж ажилласан.

3.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлж ажилласан.

4.Сайн дурын үндсэн дээр тэмдэглэлт ойн өдрүүдэд материаллаг тусалцаа үзүүлж ирсэн.

5.Ерөө сумын Баянголын гүүрнээс Корниковын давааны орой хүртэл 15 км замыг “Хандгайт гол” ХХК*тай хамтран 1 гредир өөрөө хусагч өвтомашин, 2 ачааны

Ново маркийн ачааны машин, 1 өөрөө ачигч Ковш, 1 суудлын машин, 6 хүний бүрэлдхүүнтэйгээр засаж орон нутгийн иргэдийг осол эрсдэлгүй зорчих нөхцлийг бүрдүүлсэн.

6.Тус компани нь ажиллаж байх хугацаандаа Ерөө сумын 1-р багийг малчин Цэвээн овогтой Эрдэнэцогтой мах, махан бүтээгдэхүүний гэрээг 2024.04.04-нд байгуулж ман тамс хүнсний ногоог тус багийн иргэн н.Мягмарсүрэнгээс, сүү цагаан идээг уурхайн ойр орчмын малчдаас худалдан авч хүнсний хэрэгцээгээ хангаж байна.

7. Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэрэгт тусгагдсан арга хэмжээнүүдийн цаг тухайд нь авч хэрэгжүүлсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэргийг удирдлага болгон ажилласан. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэв. Үүнд:

1.Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарч ажиллаа.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан.

3.Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад тогтмол хугацаанд сургалт зохион байгуулан ажилласан.

4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулан ажиллаж байна.

5.2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №21 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд стандартын шаардлага хангаж байгаа нь шинжилгээний хариугаар гарсан.

6.Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-тай №49/10 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж цэгцэлсэн.

7.Машин техникээс гарсан ажилласан тос, маслыг битүүмжлэл бүхий саванд цуглуулан баяжуулах үйлдвэрт дахин ашиглаж байна.

8.Төлөвлөгөөт ажил дууссаны даараа ашиглалтын болон баяжуулах үйлдвэрийн талбайн хогийг цэвэрлэн Ерөө сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.

9.Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах зорилгоор “Хүннү стийл” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргатай №03 тоот “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулан гэрээний хүрээнд орон нутагт Байгаль орчинг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цаг тухайд нь танилцуулж харилцан уялдаатай ажиллав

10.Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний

дагуу навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.

БОМТ-ний тайланг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчид цахим хэлбэрээр хүргүүлсэн.

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ-
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.ЦЭВЭЛМАА



"ХҮННУСТИЙЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
.....О.ГАНЗОРИГ





БАТЛАВ

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ

.....Л.БОЛОРМАА

2024 оны 10 дүгээр сарын 31 өдөр

БАТЛАВ

БЭРЛЭГ МАЙНИНГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

.....Ш.ЧУЛУУНБААТАР

.....оны дүгээр сарын өдөр



№ 04

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭСЭН АКТ

2024 оны 10-р сарын 31-ний өдөр

Сэлэнгэ аймаг, Ерөө сум

2024 оны 04-р сарын 22-ны өдөр байгуулсан №01 тоот Нийгмийн хариуцлагын гэрээний талууд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн, “Бэрлэг Майнинг” ХХК /тусгай зөвшөөрөл эзэмшигч/ нар Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрлийн талбайд уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн нь:

1. Гэрээний хугацаанд Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг баримтлан ажилласан байна.
 1. Гэрээний 1.2 дахь заалтын хүрээнд хийгдсэн ажлуудыг дурьвал:
 - 1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн 4 иргэнийг ашиглалтын хугацаанд байнгын ажлын байраар хангаж ажилласан.
 - 1.2 Орон нутгийн малчдаас мах, сүү цагаан идээг зах зээлийн ханшаар худалдан авч, тэдэнд шаардлагатай түлш, шатахууны туслалцаа үзүүлэх зэргээр сайн дурын дэмжлэг үзүүлж ажилласан.
 - 2.3 2024 оны 4-р сард Ялбагийн давааны гүүр нурж нутгийн иргэд зорчих боломжгүй болсоныг Бэрлэг майнинг ХХК өөрийн 3 автомашин, 2 техник, 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж гүүрийг засварлаж шинэчилсэн.
 - 2.4 2024 оны 7-р сард Цонхлонгийн даваанд гарсан гал түймрийг унтраахад хүн хүч, багаж хэрэгсэлээр хангаж ажиллав.
 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа явуулахдаа Монгол улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Татварын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаа.
 2. Гэрээний 3-р зүйлийн хүрээнд хийгдсэн ажлуудыг дурьвал:
 - 1.3 Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэргийг удирдлага болгон ажилласан.
 - 1.4 Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан дараах арга хэмжээнүүдийн цаг тухайд нь авч хэрэгжүүлсэн.
 - ✓ Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй

зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарч ажиллаа.

- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан.
 - ✓ Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад тогтмол хугацаанд сургалт зохион байгуулан ажилласан.
 - ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулж, төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Ногоо гэрэлт ирээдүй” ХХК-тай байгуулсан 2022/09 тоот гэрээний дагуу аудит хийлгэж хамтран ажилласан байна.
 - ✓ 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд хэвийн хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар гарсан.
 - ✓ Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь өөрийн 10 хүний бүрэлдэхүүнтэй, 2 техникийн тусламжтай тусгай зөвшөөрлийн талбайн баруун урагш 700 метр орчимд 2.2 га талбайд 1500 ширхэг 3 настай нарс модны суулгац тарьж ургуулан ажиллаж байна.
 - ✓ Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ОНӨААТҮГ-тай №57 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж, УБ хот дахь түүхий эд авах цэгт тушаасан. Машин техникээс гарсан ажилласан тос, маслыг битүүмжлэл бүхий саванд цуглуулан, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий “Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан №24/03 тоот “Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ”-ний дагуу хаягдал тосоо нийлүүлэн ажиллалаа.
 - ✓ 2024 оны уулын ажлын дараа нийт ашиглалтын талбай болон Ерөө голын гольдрол, эрэг дэхь хогийг цэвэрлэн Мандал сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.
- 1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ерөө сумын 100 жилийн ойд зориулан 50,000,000 /тавин сая/ төгрөгийн сайн дурын хандив тусламжийг “Бидний бахархалт Ерөө нутаг НҮТББ-д үзүүлсэн.
- 1.6 Бэрлэгийн цагаан тохойн алтны шороон ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008”, “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу 2024 оны ашиглалтын явцад эвдрэлд орсон дотоод, гадаад овоолгоор 1.75 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт,

ургамалжуулалтын ажлын хүрээнд олон наст бэлчээрийн ургамал болон бусад төрлийн ургамлуудын үрийг тариалах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэв.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ДАРГА:

..... С.ЦЭВЭЛМАА



ТУСГАИ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“БЭРЛЭГ МАЙНИНГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



..... Ш.ЧУЛУУНБААТАР